

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: /ДУА-2026/05-10-ШТА-НА/

Дундговь дахь Төрийн аудитын
газрын Дарга, тэргүүлэх аудитор
Р.Мөнхтогтох Утас: 70592439
Аудитын менежер: Т.Батсайхан
Утас: 70592225
Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn
Ахлах аудитор О.Баярсайхан
Аудитор Л.Уранбилэг
Аудитор Г.Үүрийнтуяа
Утас: 7059-2208

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим
хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Тайлан баталгаажуулах тушаал	3
Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгс	4
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	5-7
	Дүрслэлийн товъёг	8
Дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох	<u>БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хууль, журамд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлж байна.</u>	9-12
Аудитын менежер Т.Батсайхан	<u>БҮЛЭГ 2. Тайлант онд нийт 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна.</u>	13-20
Ахлах аудитор О.Баярсайхан Аудитор Л.Уранбилэг Г.Үүрийнтуяа	<u>БҮЛЭГ 3. Мэргэжлийн байгууллагаас захиалагчийн хяналт хийгддэггүй тоног төхөөрөмжийн болон шүүд худалдан авалтаар гүйцэтгэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, хүлээн авах комиссын гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.</u>	20-26
	Дүгнэлт	27
	Зөвлөмж	28
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	29
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592208 дугаарын утас, 70593208 дугаарын факсаар харилцана уу.	Хавсралтууд	30-36
ХАЯГ:		
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 213 тоот		
2026 оны 5 дугаар сар		



Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

№ 06 оны 05 сарын 12 өдөр

Дугаар 11/13

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/175 дугаар тушаалын гуравдугаар хавсралт батлагдсан “Аймаг нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх”-ийн 1, 3, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18 дугаар зүйлийн 9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан (ДУА-2026/05-10/ШТА-НА)-г нэгдүгээр, аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад тус тус хүргүүлсүгэй.

3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар заасан хугацаанд Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Дундговь аймгийн Засаг дарга (С.Мөнхчулуун)-д зөвлөсүгэй.

Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон 2026 оны 4 дүгээр улиралд танилцуулахыг аудитын хоёрдугаар нэгжийн ахлах аудитор (О.Баярсайхан)-д үүрэг болгосугай.



Р.МӨНХТОГТОХ

4826010028

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУБ	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
БББ	Бодлогын баримт бичиг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТББ	Тендерийн баримт бичиг
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНТХО	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
ХО	Хөрөнгө оруулалт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НББ	Нягтлан бодох бүртгэл
НТША	Нээлттэй тендер шалгаруулалтын арга
ШХА	Шууд худалдан авалт

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

*Аудит хийх үндэслэл, бүрэн
эрх:*

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 25 дугаар тогтоолд тусгасны дагуу “Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт”-д Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлийн аудит хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх;
- ✓ Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх;
- ✓ Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

*Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:*

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

- ✓ Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хууль,
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- ✓ Төсвийн тухай хууль,
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- ✓ Барилгын тухай хууль,
- ✓ Эрчим хүчний тухай хууль,
- ✓ Авто замын тухай хууль,
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- ✓ “Алсын хараа” 2050 Монгол Орон нутгийн урт хугацааны хөгжлийн бодлого,
- ✓ Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021- 2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”,
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
- ✓ Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан

Аудитын хамарсан хүрээ:

- “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”,
- ✓ Сангийн сайдын 2021 оны 124 дүгээр тушаалаар баталсан “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг”,
- ✓ Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”,
- ✓ Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр,
- ✓ Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл,
- ✓ Орон нутгийн 2025 оны төсөв баталсан тогтоол, түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт,
- ✓ Барилга байгууламж үнэ бүрдэл, төсөв зохиох норм ба дүрэм, стандарт,
- ✓ Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжүүд,
- ✓ Батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ, магадлалын ерөнхий дүгнэлт, ажил гүйцэтгэх гэрээ болон бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудитыг Дундговь аймагт 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний төлөвлөлт, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, түүний хэрэгжилт, олгосон санхүүжилт, эрх бүхий байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнгийн хүрээнд үндэслэн хийсэн.

Аудитын явцад Сайнцагаан суманд ажиллаж, аймгийн болон сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламжийн ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгасан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулах, тулган баталгаажуулах, түүвэрлэлт хийх зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын хөтөлбөрт дурдсан хугацаанд нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

*Аудит хийх багийн
бүрэлдэхүүн, хугацаа:*

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Т.Батсайхан үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор О.Баярсайхан, аудитор Л.Уранбилэг, Г.Үүрийнтуяа нар 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хугацаанд аудитыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын дүн

Аудитаар нийт 31,444.0 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 31,341.6 сая төгрөгийн зөрчил арилгуулахаар 10 хугацаатай албан

Үндсэн мэдээлэл

шаардлага хүргүүлж, аймгийн болон сумдын Засаг дарга нарт 102.4 сая төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж хүргүүллээ.

Дундговь аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсвийг тодотгож батлах тухай” 53 дугаар тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтаар 5,217.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй шилжих 12 төсөл, арга хэмжээ, барилга угсралт, их засварын 22 төсөл арга хэмжээг 17,697.9 сая төгрөгөөр, тоног төхөөрөмжийн 19 төсөл, арга хэмжээг 2,805.6 сая төгрөгөөр, 12 төсөл, хөтөлбөрийг 3,394.1 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр баталсан байна.

Шинээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнээс 51 буюу 96.2 хувь нь бүрэн хэрэгжих, 2 буюу 3.8 хувь нь хэрэгжээгүй байна.

Сайнцагаан, Баянжаргалан, Дэрэн, Дэлгэрцогт сумд өмнөх оны ерөнхий орлогын үлдэгдлээс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 23 төсөл, арга хэмжээнд 1,633.1 сая төгрөгийг батлан хэрэгжүүлжээ.

Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээг хийж гүйцэтгүүлэхээр гүйцэтгэгч компаниудтай нийт 30,479.1 сая төгрөгийн гэрээ байгуулжээ. Үүнээс 29,532.1 сая төгрөгийг тайлант онд санхүүжүүлэхээс 18,889.6 сая төгрөгийн санхүүжилт олгож 63.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ОНТХО-ын 2024, 2025 онуудын төлөвлөлт болон эх үүсвэрийн өөрчлөлт	9
Хүснэгт 2	Төлөвлөсөн ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	10
Хүснэгт 3	Хөтөлбөр болон өмнөх оноос шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээг оруулаагүй болно.	11
Хүснэгт 4	Сумдын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-г ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан байдал	14
Хүснэгт 5	Зарласан худалдан авах ажиллагааны төрөл	14
Хүснэгт 6	Адаацаг сумын Төрийн үйлчилгээний автомашин худалдан авах ажилд зохион байгуулагдсан тендерийн мэдээлэл	15
Хүснэгт 7	Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-нд зарласан ХАА-ний төрөл	15
Хүснэгт 8	Хуулийн хугацаанд хэрэгжүүлж дуусаагүй ТАХ-ний мэдээлэл	16-17
Хүснэгт 9	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн цаглаварт хугацаа зөрчиж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт	17-18
Хүснэгт 10	Шаардлагад нийцээгүй оролцогч шалгаруулсан ТАХ-ний шалтгаан, нөхцөл байдал	19
Хүснэгт 11	Тайлант онд гарсан гомдлын тоо, шийдвэрлэсэн хувь	19
Хүснэгт 12	Сангийн яам хүлээн авсан гомдлын тоо, шийдвэр	20
Хүснэгт 13	ТАХ-ний хэрэгжилт	21
Хүснэгт 14	Санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал /сая төгрөгөөр/	22

Графикийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График-1	Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтыг ТАХ-ний ангиллаар харуулав.	9
График-2	Сүүлийн 3 жилийн хугацаанд аймгийн БББ-тэй уялдуулан төлөвлөөгүй зөрчлийн хувь	10
График-3	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ-ний дүн	13
График-4	Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулсан байдал	16
График-5	Нийт зарласан ХАА-ны дүн	18



БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хууль, журамд заасан шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн нь гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

А.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө аймгийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлж байгаа хэдий ч нэн тэргүүний хэрэгцээ шаардлагаар эрэмбэлэх ажил хууль, журмын дагуу хийгдэхгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрөнгийн бус шинжтэй, арга хэмжээг төлөвлөн баталж, зарцуулж байгаа нь холбогдох хууль, журамтай зөрчилдөж байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд нийт 35,368.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 33,095.6 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 72 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөж баталжээ. Аймгийн төсөвт 1 удаа өөрчлөлт оруулж, ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 53 дугаар тогтоолоор 32,917.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 29,532.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 67 хөтөлбөр, төсөл, арга хэмжээ болгож баталсан байна. Энэ нь тус онд санхүүжих хөрөнгө оруулалтыг анхны батлагдсан төсвөөс 3,563.6 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.

Хүснэгт-1: ОНТХО-ын 2024, 2025 онуудын төлөвлөлт

Төсөл, арга хэмжээний төрөл	Батлагдсан төсөв /сая төгрөгөөр/							
	2024 он		2025 он /11/		2025 он /53/		Өөрчлөлт	
	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн	ТАХ-ний тоо	Санхүүжих дүн
1. Шилжих ХО	6	399.4	17	6,770.8	13	5,634.4	(4)	(1,136.4)
1.1 Барилга байгууламж	3	305.2	8	2,133.2	6	2,108.3	(2)	(24.9)
1.2.Тоног төхөөрөмж	2	56.1	6	2,953.4	5	2,666.5	(1)	(286.9)
1.3 Их засвар	1	38.1	2	1,242.0	1	417.4	(1)	(824.6)
1.4 Зөвлөх үйлчилгээ	-	-	1	442.2	1	442.2	0	-
2. Шинэ ХО	80	22,072.5	55	26,324.8	54	23,897.6	(1)	(2,427.2)
2.1 Барилга байгууламж	33	12,009.7	14	13,515.8	11	12,748.6	(3)	(767.2)
2.2 Тоног төхөөрөмж	27	4,068.1	17	2,911.1	19	2,805.6	2	(105.5)
2.3 Их засвар	10	2,184.6	12	5,597.9	12	4,949.3	0	(648.6)
2.4 Хөтөлбөр	10	3,810.1	10	3,950.0	10	2,669.1	0	(1,280.9)
2.5 Зөвлөх үйлчилгээ	-	-	2	350.0	2	725.0	0	375.0
Нийт ОНТХО-ын дүн	86	22,471.9	72	33,095.6	67	29,532.0	(5)	(3,563.6)

Хүснэгтээс харахад шилжих болон шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн ажлыг нийт санхүүжих дүнгийн 58.1 хувь буюу 17,150.4 сая төгрөгөөр, их засварын ажлыг 18.2 хувь буюу 5,366.7 сая төгрөгөөр, тоног төхөөрөмж бэлтгэх ажлыг 12.3 хувь буюу 3,620.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.




График-1: Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтыг ТАХ-ний ангиллаар харуулав.

Орон нутгийн төсвийн нийт хөрөнгө оруулалтын 3,394.1 сая төгрөгийг төсөл хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөжээ.

Засаг даргын дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд

чиглэсэн Хүний нөөцийг дэмжих хөтөлбөр, Аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр, Нээлттэй Дундговь хөтөлбөр, Сүү хөтөлбөр зэрэг хөрөнгийн бус шинж чанартай, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүртгэх боломжгүй хөтөлбөрийг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй хамт төлөвлөн баталж, зарцуулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24¹, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2²-д заасантай нийцэхгүй байна. Иймд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөж батлахдаа хөрөнгийн бус шинж чанартай, төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр хамтад нь батлахгүй байх нь зүйтэй. Энэ талаар аймгийн ИТХ болон Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

Аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.


Аймгийн төсөв баталсан ИТХ-ын 2024 оны 11 дүгээр тогтоолоор шинээр 55, төсөвт тодотгол хийсэн 2025 оны 53 дугаар тогтоолоор нэмж 11, нийт 66 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Эдгээр төсөл, арга хэмжээний 97.0-98.5 хувь нь аймгийн дунд хугацааны бодлогын баримт бичиг болох аймгийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдсан, тодорхойлсон зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна. Хүснэгтээр харуулав.

Хүснэгт-2: Төлөвлөсөн ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал

Төлөвлөсөн ТАХ бодлогын баримт бичигтэй нийцсэн байдал	Нийцсэн		Нийцээгүй	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
"Аймаг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл"	64	97.0	2	3.0
"Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"	65	98.5	1	1.5

Сүүлийн 3 жилийн хугацаанд аймгийн бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөөгүй зөрчлийн хувийг графикаар харуулбал:

График-2: Сүүлийн 3 жилийн хугацаанд аймгийн БББ-тэй уялдуулан төлөвлөөгүй зөрчлийн хувь



Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан төлөвлөөгүй өмнөх оноос 7.8-10.9 хувиар буурч 1.5-3.0 хувьд хүрсэн байна. Иймд өмнөх аудитаар өгсөн зөрчил давтан гаргахгүй байх албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллажээ.

A.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлэхгүй төлөвлөсөн зөрчил буурахгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг аймгийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөж байгаа боловч хууль, тогтоомжийн дагуу зураг төсөвгүй, магадлалын ерөнхий дүгнэлтгүй, ТЭЗҮ-гүй төлөвлөсөн зөрчил гарсаар байна.

Аймгийн төсвийг тодотгосон ИТХ-ын 2025 оны 53 дугаар тогтоолоор баталсан 54, өмнөх төсөв батлах тогтоолоор батлагдаж, энэ тогтоолоор хасагдсан 12, нийт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 56 төсөл, арга хэмжээг хууль, журамд нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг хүснэгтээр харууллаа. /Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан 10 төсөл, хөтөлбөрийг оруулаагүй болно./

¹ "хөрөнгө оруулалт" гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

² Хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ;

Хүснэгт- 3. Хууль, журмын шаардлагад нийцсэн эсэх

ТАХ-ний ангилал	Төлөвлөсөн ТАХ-ний тоо	Зураг төсөв, ТЭЗҮ-тэй эсэх		Ерөнхий магадлал болон эрх бүхий этгээдээр хянагдсан эсэх	
		Тийм	Үгүй	Тийм	Үгүй
Барилга, байгууламж	18	16	2	9	9
Тоног төхөөрөмж	21	21	0	8	13
Их засвар	14	13	1	9	5
Зөвлөх үйлчилгээ	3	2	1	2	1
Дүн	56	52	4	28	28

Шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн барилга, байгууламжийн 18 төсөл, арга хэмжээний 2 буюу 11.1 хувь нь зураг, төсөвгүй, 9 буюу 50.0 хувь нь зураг, төсвөө Барилга хөгжлийн төвийн ерөнхий магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй байна. Их засварын 14 ажил төлөвлөснөөс 1 буюу 7.1 хувь нь зураг, төсөвгүй, 4 буюу 35.7 хувь нь зураг, төсвөө магадлалын дүгнэлтээр баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээ төлөвлөжээ.

Мөн Авто тээврийн газрын дэд бүтцийн засвар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт “Unitel Hub” өрөө байгуулах ажлыг зураг төсөвгүй, ашиглагч байгууллага ажлын даалгавар боловсруулан баталж гүйцэтгүүлсэн байна. Энэ нь мэргэжлийн төсөвчний боловсруулсан зураг, төсөвгүй учир холбогдох норм нормативын дагуу хийгдэж байгаа эсэхэд мэргэжлийн байгууллагаас хяналт тавих боломжгүй болж, чанаргүй хийгдэх, хөрөнгө оруулалтыг үр ашиггүй болгох нөхцөл үүссэн байна. Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлжээ.

Дээрх зөрчлүүд Төсвийн тухай хуулийн 29¹.2.2³ дох хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3⁴, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.2.2⁵-г заасантай нийцэхгүй байна.

Батлагдсан зураг төсөвгүй, магадлалаар баталгаажуулаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд багтаан зохион байгуулах боломжгүй болж төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх, чанаргүй хийгдэх эрсдэл үүсэж байна.

Иймд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журмын шаардлага хангуулан төлөвлөж, богино хугацаанд хэрэгжүүлэн, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх нь зүйтэй байна.

Тоног төхөөрөмж бэлтгэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, үзүүлэлт, төсөвт өртгийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн боловсруулахгүй, түүнд тавих хяналт сул байгаа нь чанаргүй хөрөнгө бэлтгэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг бий болгож байна.

Сум, албан байгууллага нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналаа аймгийн ЗДТГ-ын хөрөнгө оруулалт хариуцсан нэгжид шаардлагатай тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт, төсөвт өртгийн мэдээллийн хамт хүргүүлэн шийдвэрлүүлдэг байна.

Тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалтаар тоног, төхөөрөмж бэлтгэх 21 төсөл, арга хэмжээг төлөвлөжээ. Үүнээс 1,504.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулсан албан тушаалтан тодорхойгүй, эрх бүхий этгээд хянан баталгаажуулаагүй, барааны төсөвт өртгийг тогтоохдоо зах зээлийн бодит үнэ ханшийг судалсан нотлох баримт байхгүй, зах зээлийн үнээс өндрөөр төсөвт өртгийг тооцож төлөвлөсөн байна. /Дэлгэрэнгүйг Хавсралт-2.-оос үзнэ үү./

³барилга байгууламжийн хувьд Барилгын тухай хуулийн 4.1.30-д заасан зураг төсөл болон сүүлийн хоёр жилийн хугацаанд хийгдсэн магадлалаар баталгаажсан төсөвтэй байх;

⁴Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ;

⁵барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

Тухайлбал:

- “Халаалтын зуухнуудын шинэчлэл” төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг эрх бүхий этгээд хянаагүй, хэн боловсруулсан нь тодорхойгүй, боловсруулахдаа мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөгөө аваагүй, төсөвт өртгийг зах зээлийн бодит үнийг судлан тогтоосон эсэх нотлох баримт байхгүй;
- Авто тээврийн газарт “Хүнд даацын автомашины жин хэмжигч зөөврийн авто пүү” бэлтгэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг эрх бүхий этгээд хянаагүй, хэн боловсруулсан нь тодорхойгүй, боловсруулахдаа мэргэжлийн байгууллагаас заавар, зөвлөгөө аваагүй, үзүүлэлтийг бүрэн тодорхойлоогүй, нэг тэнхлэг дээрээ хэдэн тонн хэмжихийг тодорхой тусгаагүй, эрх бүхий мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан байх шаардлагыг тусгаагүй, төсөвт өртгийг зах зээлийн бодит үнээс 3-4 дахин өндөр үнээр төлөвлөж төсөвт тусган баталсан байна. Төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж бэлтгэх бараа, тоног төхөөрөмжийн тодорхойлолтод хяналт тавьж, баталгаажуулах ажил хангалтгүй байна.

Энэ нь “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.2.3.3⁶-д заасан тоног төхөөрөмжийн төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг хангахгүй байгаа бөгөөд зах зээлийн үнээс өндрөөр хөрөнгө бэлтгэж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлтэй байна. Иймд дээрх зөрчлүүдийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг холбогдох албан тушаалтанд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Цаашид тоног төхөөрөмж бэлтгэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа ашиглалтын шаардлага хангахуйц үзүүлэлттэй, зах зээлийн үнийн ханшийн судалгааг хийж, төсөвт өртгийг бодитой тооцсон эсэхэд эрх бүхий албан тушаалтан хяналт тавьж баталгаажуулан төлөвлөж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар зарцуулах нь зүйтэй.

Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ төлөвлөхдөө үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо зэрэг холбогдох тооцоог хийж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргахгүй байна.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 18 барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээг шинээр санхүүжүүлэх төлөвлөсөн. Эдгээр барилга, байгууламжийн ажлуудаас Цагаандэлгэр сумын Хөгжлийн төвийн барилга, Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах, Говь-Угтаал сумын Спорт заалны барилгын дуусгалын төсөл, арга хэмжээний үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо зэрэг холбогдох тооцоог хийж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29¹ дүгээр зүйлийн 29^{1.2.4}⁷ дэх хэсэгт заасан шалгуурыг хангахгүй байна. Мөн Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 2.2.4⁸ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төсөл, арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох тооцоо, судалгаа хийлгүйгээр хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн нь хууль тогтоомж зөрчих, орон нутгийн төсөвт нэмэлт ачаалал үүсгэх, шаардлагагүй хөрөнгө бий болох зэрэг үр дагавартай байна.

Иймд хөрөнгө оруулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн, цаашид гарах үр дагаврыг цогцоор нь тооцож судлан үр ашигтай төсөл, арга хэмжээг төлөвлөж байх нь зүйтэй.

⁶Холбогдох баримт бичиг, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

⁷ урсгал зардал гарах төслийн урсгал зардлыг тооцсон байх;

⁸ Төсөл, арга хэмжээний саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;



БҮЛЭГ 2. Тайлант онд нийт 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу амжилттай зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон байна.


Б.1 Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан 46 төсөл, арга хэмжээний 45 нь амжилттай болж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Зарим сумд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, цахим системээр илгээгээгүй байна.

Тайлант онд нийт 47 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар батлагдсан байна. Үүнээс 1,095.6 сая төгрөгийн төсөвтэй 2 төсөл, арга хэмжээ нь өмнөх оноос шилжиж ирсэн төсөл, арга хэмжээ байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 26,590.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 24,035.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 46 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар тусгасан байна. Харин 30.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хөдлөх хөрөнгийн их засварын ажлыг худалдан авах ажиллагаанд тусгаагүй байна.

График-3: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ТАХ



Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээний 26.1 хувь нь барилга байгууламжийн ажилд, 23.9 хувь нь их засварын ажилд, 45.7 хувь бараа, тоног төхөөрөмжийн худалдан авалтад, үлдсэн 4.3 хувь нь үйлчилгээ байна.

Аймгийн Засаг дарга ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7⁹-т заасныг үндэслэн 1,504.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 934.4 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 4 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг төсөв батлагдсанаас ажлын 7 өдөрт буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдөр А/957 дугаар захирамжаар холбогдох сумдын Засаг дарга нарт шилжүүлжээ. Үүнд:

- Өвс тэжээлийн агуулахын барилга /Өндөршил сум/
- Төрийн үйлчилгээний автомашин /Адаацаг сум/
- Хулд сумын төрийн албан хаагчдын байрны их засвар
- Эрдэнэдалай сумын ЕБС-ийн дээврийн засвар

⁹ 45.7.Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ.

Тайлант онд 4 сум орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 24 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт- 4: Сумдын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-г ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан байдал

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх сум	Батлагдсан төсөл, арга хэмжээний тоо	Нийт төсөвт өртөг	ХАА-ны төлөвлөгөөнд тусгавал зохих	ХАА-ны төлөвлөгөөнд тусгавал зохих дүн	ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан	ХАА-ны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөг
Сайнцагаан	5	1,230.0	4	830.0	4	830.0
Баянжаргалан	3	204.5	3	204.5	3	204.5
Дэлгэрцогт	9	69.8	7	34.7	0	-
Дэрэн	7	90.0	3	37.0	0	-
Нийт	24	1,594.3	17	1,106.2	7	1,034.5

Сайнцагаан, Баянжаргалан сумд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг сумын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна.

Харин Дэрэн, Дэлгэрцогт сумд орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган батлуулаагүй, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2¹⁰, 44.3¹¹-г тус тус заасан үүргээ биелүүлээгүй байна. Энэ нь худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд тавих хяналт сулрах, хуульд заасан цаглаварт хугацаанд гүйцэтгэхгүй байх, төсвийг үр ашиггүй зарцуулах зэрэг эрсдэлийг бий болгож байна.

Цаашид орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан дарууд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталж, хуульд заасан хугацааны дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх, хэрэгжилтийг тайлагнах шаардлагатай байна.

“Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг зөрчин, 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Адаацаг сумын Төрийн үйлчилгээний автомашин худалдан төсөл, арга хэмжээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан 47 төсөл, арга хэмжээнээс 2-т нь батлагдсан зураг төсөв, ажлын даалгавар, тоо хэмжээ, техникийн тодорхойлолт бүрдээгүй тул худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна. Үүнд:

- Хөгжлийн төвийн шинэ барилга /Цагаандэлгэр сум/
- Хөдлөх хөрөнгийн их засвар

Хүснэгт-5: Зарласан худалдан авах ажиллагааны төрөл

ТАХ-ний ангилал	Нээлтгэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга	Шууд худалдан авалт	Нийт
Барилга, байгууламж	10	-	1	11
Тоног төхөөрөмж	9	7	5	21
Их засвар	10	1	-	11
Үйлчилгээ	2	-	-	2
Нийт	31	8	6	45

¹⁰ 44.2. Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна.

¹¹ 44.3. Захиалагч санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 өдрийн дотор худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр илгээнэ.

Дээрх хүснэгтээс харахад нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 31, харьцуулалтын аргаар 8, шууд худалдан авалтын аргаар 6 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнээс 44 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын аргыг холбогдох хууль журмын дагуу сонгосон бол Адаацаг сумын Засаг даргад эрх шилжүүлсэн 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Төрийн үйлчилгээний автомашин худалдан авах төсөл, арга хэмжээг батлагдсан журмыг зөрчин харьцуулалтын аргаар зарласан байна.

Хүснэгт-6: Адаацаг сумын Төрийн үйлчилгээний автомашин худалдан авах ажилд зохион байгуулагдсан тендерийн мэдээлэл

Урилгын дугаар	ХАА-ны журам	Тендер зарласан огноо	Тендер нээсэн огноо	Тендер нээх хүртэлх ажлын өдөр
ДУАХААГ/20250102018/02/01	НТША	2025.03.24	2025.04.15	16
ДУАХААГ/20250102018/03/01	НТША	2025.04.25	2025.05.07	8
ДУАХААГ/20250102018/04/01	ХА	2025.05.20	2025.05.28	6

Хүснэгтэд дурдсанаар эхний 2 тендер шалгаруулалтыг журмын дагуу нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан боловч 3 дахь удаагийн тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар зарлаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 31.1¹² дэх заалт, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”¹³-ийг зөрчсөн байна.

Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3¹⁴-т заасны дагуу Адаацаг сумын Засаг даргад хүргүүлээ.

Харин сумдын 17 төсөл, арга хэмжээг сумдын орон нутгийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бөгөөд эдгээрийн худалдан авах ажиллагааны хэлбэрийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сонгосон байна.

Хүснэгт-7: Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн ТАХ-ний худалдан авах ажиллагааны төрөл

ТАХ-ний ангилал	Нээлттэй тендер шалгаруулалт	Харьцуулалтын арга	Шууд худалдан авалт	Нийт
Сайнцагаан	3	-	1	4
Баянжаргалан	1	-	2	3
Дэлгэрцогт	-	-	7	7
Дэрэн	-	-	3	3
Нийт	4	-	13	17

Тайлант онд 1 төсөл, арга хэмжээг хүчингүй болсон жишиг баримт бичгийг үндэслэн тендер шалгаруулалтыг зохион байгуулсан байна.

Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай” А/103, А/104, А/105, А/106 дугаар тушаалаар тендер шалгаруулалтын жишиг баримт бичгүүдийг шинэчлэн баталжээ. Шинэчлэгдсэн жишиг баримт бичигт цахим систем ашиглах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өмнөх жишиг баримт бичигт тусгагдсанаас илүү нарийвчлан зохицуулсан байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн нийт 39 төсөл, арга хэмжээнээс 31 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2025 оны 5 дугаар сарын 26-наас өмнө, 2023 онд батлагдсан жишиг баримт бичгээр үлдсэн 8 төсөл арга хэмжээг шинэчлэгдсэн жишиг баримт бичгээр тус тус зохион байгуулсан байна.

¹² 34.1. Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно.

¹³ 1. Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Бараа-20.0, Ажил-20.0, Үйлчилгээ-20.0/;

2. Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар /Бараа-100.0, Ажил-150.0, Үйлчилгээ-100.0/

¹⁴ 48.3. Захиалагчийг төлөөлөх этгээд энэ хуулиар олгогдсон эрх, үүргийг тухайн байгууллагын холбогдох бусад этгээдэд шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Говь-Угтаал сумын Спорт заалны барилгын дуусгал, гадна шугам сүлжээний ажлын үнэлгээний хороо тендер шалгаруулалтын баримт бичгийг 2025 оны 08 дугаар сарын 18-ны өдөр боловсруулсан бөгөөд ингэхдээ хүчингүй болсон тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийн дагуу боловсруулж, батлуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1¹⁵-д заасныг зөрчсөн байна.

Тендерийн шалгаруулалтын хугацаанд оролцох хүсэлтэй этгээдээс 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдөр ТШББ-ын тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд тэгш оролцох боломжийг хязгаарласан заалтууд байсан гэж үзэн ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1¹⁶-т дагуу захиалагчид гомдол гаргасан байна. Гомдлын дагуу аймгийн Засаг дарга холбогдох хууль, журмын хүрээнд хянан гомдол үндэслэлтэй гэж үзэн ТШББ-д өөрчлөлт оруулах чиглэлийг Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээний хороо 2025 оны 08 дугаар сарын 25-ны 2 дугаар хурлаар гомдолд дурдсан ТШББ-ын өгөгдлийн хүснэгтэд тусгагдсан тэгш оролцох боломжийг хязгаарласан 3 шалгуурт өөрчлөлт оруулж тендер шалгаруулалтыг үргэлжлүүлсэн байна.

Аймаг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зохион байгуулсан байна.

График-4: Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулсан байдал



“Төрийн хэмнэлтийн тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1¹⁷-т төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад баримтлах журмыг заасан бөгөөд 13.1.1¹⁸-т төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг тухайн оны 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгахад цаглаварт хугацааг

тогтоосон. Тайлант онд хэрэгжүүлсэн нийт 45 төсөл, арга хэмжээний 76 хувь буюу 34 төсөл арга хэмжээний худалдан авалтыг хуульд заасан цаглаварт хугацаанд зохион байгуулж гүйцэтгэгч байгууллагатай гэрээ байгуулсан, 7 хувь буюу 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг цаглаварт хугацаанд дуусгаагүй 17 хувь буюу 8 төсөл, арга хэмжээг цаглаварт хугацааны дараа хэрэгжүүлсэн байна.

Худалдан авах ажиллагаа хуулийн цаглаварт хугацаанд амжаагүй, үргэлжилж байсан төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулав.

Хүснэгт-8: Хуулийн хугацаанд хэрэгжүүлж дуусаагүй ТАХ-ний мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	Тендер шалгаруулалт			ХАА зохион байгуулсан удаа /тоо/	Гэрээний огноо
		Үнэлгээний хороо байгуулсан огноо	Анх зарласан огноо	Дууссан огноо		

¹⁵ 11.1. Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.

¹⁶ 57.1. Захиалагч тендер шалгаруулалттай холбоотой хуульд заасан үүргээ зөрчсөн гэж үзвэл сонирхогч этгээд, оролцогч энэ тухай мэдсэнээс хойш ажлын таван өдрийн дотор захиалагчид бичгээр гомдол гаргаж болох бөгөөд гомдолд зөрчлийг нотлох баримтыг хавсаргана.

¹⁷ 13.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахад дараах журмыг баримтална

¹⁸ 13.1.1. батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах

1	Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах	2025.05.08	2025.05.08	2025.08.01	1	2025.09.11
2	Аймгийн төвийн халаалт, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, засварын ажлын материал /Багц-1/	2025.04.29	2025.05.01	2025.10.20	4	-
3	Хулд сумын төрийн албан хаагчдын байрны их засвар	2025.04.11	2025.04.18	2025.06.12	2	2025.06.16

Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын тендерийг нэг удаа ажлын 60 хоногийн хугацаатай зарласан байна. Харин Хулд сумын төрийн албан хаагчдын байрны их засварын ажлын гүйцэтгэгч шалгаруулах тендерийг 2 удаа зарласан ба эхний тендер шалгаруулалт оролцогчгүй байснаар амжилтгүй болж дараагийн тендерийг тайлант оны 05 дугаар сарын 21-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулж цаглаварт хугацааны дараа гэрээ байгуулах эрх олгосон байна.

Аймгийн төвийн халаалт, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, засварын ажлын материал нийлүүлэх төсөл, арга хэмжээний тендерийг ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5¹⁹-т заасныг үндэслэн 2 багц болгон тендерийг зарласан байна. Анхны тендерийг 2025.05.01-нээс 2025.05.26-нд зарлаж, 2-р багцын гүйцэтгэгчийг шалгаруулсан бол 1-р багц оролцогчгүй байсан байна.

Уг тендерийн 1-р багцын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг дахин 3 удаа 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл зарлаж оролцогчгүй байсан учир амжилтгүй болсон байна.

Харин хуулийн цаглаварт хугацаанаас хойш гүйцэтгэгчийг шалгаруулсан 8 төсөл, арга хэмжээ нь аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн “Аймгийн 2025 оны төсөв тодотгож батлах тухай” 53 дугаар тогтоолоор шинээр баталж, хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ байна.

Хүснэгт-9: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн цаглаварт хугацаа зөрчиж худалдан авах ажиллагаа зохион байгуулсан ТАХ-ний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Тендер			ХАА зохион байгуулсан удаа /тоо/	Гэрээ байгуулсан огноо
		Үнэлгээний хороо байгуулсан огноо	Зарласан огноо	Дууссан огноо		
1	Төв цэвэрлэх байгууламжаас Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэрт дэд бүтэц татах	2025.08.13	2025.09.11	2025.10.23	1	2025.11.04
2	Дулаан дамжуулах шугамын ажил, 3 дугаар хэсэг /Сайнцагаан сум/	2025.08.13	2025.08.13	2025.09.10	1	2025.09.11
3	Дулаан дамжуулах шугамын ажил, 4 дүгээр хэсэг /Сайнцагаан сум/	2025.08.13	2025.08.13	2025.09.10	1	2025.09.18
4	Халаалтын зуухнуудын барилгын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/	2025.08.13	2025.08.13	2025.09.11	1	2025.06.05
5	Зөөврийн хурд хэмжигч багаж	2025.08.13	2025.08.21	2025.09.10	1	2025.09.26
6	Эрдэнэдалай сумын шинэ цэцэрлэгийн зөөлөн эдлэл	2025.08.13	2025.08.28	2025.09.17	1	2025.09.29
7	Дундговь аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө	2025.08.13	2025.08.21	2025.09.17	1	2025.09.19

¹⁹ 10.5. Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно.

8	Спорт заалны барилгын дуусгал /Дундговь, Говь-Угтаал сум/ Гадна шугам сүлжээний ажил	2025.08.13	2025.08.18	2025.09.11	1	2025.09.19
---	--	------------	------------	------------	---	------------

Мөн Сайнцагаан сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Мандлын гэгээ ХТГ-ын хэрэгцээнд бункер өргөгч автомашин авах төсөл, арга хэмжээг Сайнцагаан сумын ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 30 дугаар тогтоолоор баталсан төсвийн тодотголоор нэмж батлан, хуулийн цаглаварт хугацаанаас хойш гүйцэтгэгчийг шалгаруулсан байна.

Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зохион байгуулж гэрээ байгуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1²⁰, 13.1.2²¹, 13.1.3²², 13.1.4²³ дэх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна. Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймгийн болон Сайнцагаан, Хулд сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.


Иймд батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн цаглавар хугацаанд багтаан зохион байгуулж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй.

Нийт худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 45 төсөл, арга хэмжээний 97.8 хувь буюу 44 гүйцэтгэгчийг амжилттай шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Тайлант онд аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 6 төсөл, арга хэмжээг шууд худалдан авалтаар гүйцэтгэсэн бол 39 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалт болон харьцуулалтын аргаар нийт 62 удаа тендер зарсан байна. Тус 39 төсөл, арга хэмжээний 37 төсөл, арга хэмжээ, 1 төсөл, арга хэмжээний багцын тендер шалгаруулалт амжилттай болж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Дэрэн сумын төрийн албан хаагчдын байрны их засвар, гадна шугам сүлжээ болон аймгийн төвийн халаалт, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, засварын ажлын материал нийлүүлэх ажлын 1-р багцын тендер шалгаруулалтыг тус бүр 3-4 удаа зарлаж амжилтгүй болж гүйцэтгэгчийг шалгаруулж чадаагүй байна.

График-5: Нийт зарласан ХАА-ны дүн



Нийт зарласан 62 удаагийн тендер шалгаруулалтын 61.3 хувьд нь гүйцэтгэгч амжилттай шалгарч гэрээ байгуулсан байна. Харин 16.1 хувь нь шаардлага хангасан оролцогчгүй, 20.1 хувь нь

²⁰ 13.1.1.батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах;

²¹ 13.1.2.энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох;

²² 13.1.3.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх;

²³ 13.1.4.төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх;

оролцогчгүй, 3.2 хувь нь дундаа зогссоны улмаас тус тус амжилтгүй болсон. Үүнээс 26 төсөл, арга хэмжээний тендер анхны удаа зарлагдаад амжилттай болжээ.

Хүснэгт-10: Шаардлагад нийцээгүй оролцогч шалгаруулсан ТАХ-ний шалтгаан, нөхцөл байдал

Төсөл, арга хэмжээний нэр	Нөхцөл байдал	Шалтгаан
Дулаан дамжуулах шугамын ажил, 3 дугаар хэсэг /Сайнцагаан сум/	Гүйцэтгэгчээр шалгарсан байгууллага нь Ажил гүйцэтгүүлэх ТШББ-ийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 17.3 дахь хэсэгт тусгасан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь тус чиглэлээр 124-өөс багагүй багц цагийн сургалтад хамрагдсан гэрчилгээ авсан, 1-с доошгүй ажилласан жилийн туршлагатай байх” гэсэн шаардлагад ажилласан жилийн туршлага 1 жил хүрэхгүй, шаардлага хангаагүй ажилтныг санал болгосон байна. Тендер шалгаруулалтыг нээх үед хөтөлдөг Маягт 3-ийн “Техникийн тодорхойлолтын шаардлагад нийцэх эсэхийг хянан үзсэн тэмдэглэл”-д ТШЗ 17.1-р шаардлагыг үнэлээгүй.	Үнэлгээний хорооны нарийн бичиг буюу ХААГ-ын ХАА хариуцсан мэргэжилтэн дахин тендер зарлах санал гаргасан боловч тус ажил нь өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд яаралтай хийгдэх шаардлагатай, дахин тендер зарлах хугацаа байхгүй гэж үзсэн тул тендер шалгаруулалтыг амжилттай болгохоор шийдвэрлэсэн. Бусад оролцогчид хэд хэдэн шаардлага хангаагүй харин гүйцэтгэгч байгууллагын санал болгосон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан нь 124-өөс багагүй багц цагийн сургалтад хамрагдсан гэрчилгээтэй, мөн бусад шаардлагад нийцсэн тул үнэлгээний хорооны гишүүдийн 80 хувийн саналаар гэрээ байгуулах эрх олгосон.

Б.2 Тендерт шалгаруулалттай холбоотой 7 гомдол гарсны 2 гомдлыг үндэслэлтэй гэж үзэн гомдол гаргагчийн талд шийдвэрлэсэн байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой гарсан гомдлыг хууль журмын дагуу хүлээн авч, хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Тайлант онд нийт 5 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад 7 удаагийн гомдол гарснаас 1 гомдол нь тендер шалгаруулалтын явцад захиалагчид гаргасан бол 6 удаагийн гомдлын хувьд тендерийн үр дүнг нийтэлснээс дараа Сангийн яаманд хүргүүлсэн гомдол байна.

Хүснэгт-11: Тайлант онд гарсан гомдлын тоо, шийдвэрлэсэн хувь

Гомдол гарсан ТАХ-ний тоо	Гомдлын тоо		Гомдол хүлээж авсан байдал	Гомдол хянасан байдал			
5	7	Тендер шалгаруулалтын явцад	1	Хүлээж авч хянасан	5	Захиалагчийн талд	40%
		Үр дүн нийтэлсний дараа	6	Хүлээн авахаас татгалзаж буцаасан	2	Гомдол гаргагчийн талд	60%

Сангийн яаманд хүргүүлсэн гомдлын 2 нь Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 4.6²⁴-д заасныг үндэслэн гомдлыг хүлээж авах боломжгүй гэж үзсэн байна.

Дулаан дамжуулах шугамын 4-р хэсгийн ажил, Эрдэнэдалай сумын шинэ цэцэрлэгийн зөөлөн эдлэлийн гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2 дахь хэсэгт заасныг зөрчин зохион байгуулсан нь дээрх гомдлуудыг хүлээж авах боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Аймгийн Засаг дарга буюу захиалагчид ирсэн гомдлын талаар тайлангийн 16 дугаар хуудсанд дурдсан болно.

²⁴ 4.6. Сангийн яам энэ журмын 4.1, 4.2, 4.3, 4.4, 4.5-д заасныг зөрчсөн, эсхүл санхүүжилтийн эх үүсвэргүй болсон тендер шалгаруулалттай холбоотой гомдлыг хуулийн 59.5-д заасныг үндэслэн хүлээн авахаас татгалзаж буцаана.

Харин бусад 3 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад гарсан 4 гомдол нь тендерт шаардлага хангаагүй оролцогчийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай гомдол байна. Тус гомдлуудыг Сангийн яам хүлээн авч ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасны дагуу дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт-12: Сангийн яам хүлээн авсан гомдлын тоо, шийдвэр

Гомдол гарсан төсөл, арга хэмжээний нэр	Гомдол гарсан тоо	Гомдол шийдвэрлэсэн байдал		
		Үндэслэлтэй	Үндэслэлгүй	Шийдвэр
Камерын нэгдсэн удирдлагын төвийн байрны их засвар	1	1	-	Гомдол гаргагчийн талд
Аймгийн 18 ЕБС, 22 цэцэрлэгт аяга таваг угаагч, ариутгагч	1	-	1	Захиалагчийн талд
Халаалтын зуухнуудын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/	2	1	-	Гомдол гаргагчийн талд
		-	1	Захиалагчийн талд

Хүснэгтэд харуулснаар Сангийн яам 2 гомдлыг үндэслэлтэй гэж үзэн ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1²⁵-ын дагуу аймгийн Засаг даргын гэрээ байгуулах эрх олгосон шийдвэрийг хүчингүй болгож, 2 гомдлыг үндэслэлгүй байна гэж үзэн хуулийн 59.10.2²⁶-т заасны дагуу тендерийг хянан үзэх, үнэлэх ажиллагааг дахин хийхийг мэдэгдсэн байна.

Тайлант онд нийт 5.9 сая төгрөгийн тендерийн баталгааг улсын орлого болгож, төрийн сангийн тендерийн баталгааны дансанд төвлөрүүлжээ.

Сангийн яамнаас гомдол гаргагчийн талд шийдвэрлэсэн шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг дарга үнэлгээний хороог дахин байгуулсан. Камерын нэгдсэн удирдлагын төвийн байрны их засварын ажлын үнэлгээний хороо тендерийг дахин хянан, үнэлэхдээ шаардлага хангаагүй тендерийн баримт бичгийн заалтаар гүйцэтгэгчээс тодруулга аван гэрээ байгуулах эрх олгосон байна. Харин халаалтын зуухнуудын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/ төсөл, арга хэмжээнд шаардлага хангасан оролцогч байхгүй учир тендерийг дахин зарласан.

Сангийн яам тендер шалгаруулалтад оролцогчоос гаргасан 2 гомдлыг бүхэлдээ үндэслэлгүй гэж үзэн ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6.3²⁷ дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын 5.13²⁸-т үндэслэн дор дурдсан тендерийн баталгааг улсын орлого болгосон байна. Үүнд:

- Аймгийн 18 ЕБС, 22 цэцэрлэгт аяга таваг угаагч, ариутгагч - 1.8 сая төгрөг
- Халаалтын зуухнуудын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/ - 4.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 3. Мэргэжлийн байгууллагаас захиалагчийн хяналт хийгддэггүй тоног төхөөрөмжийн болон шууд худалдан авалтаар гүйцэтгэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, хүлээн авах комиссын гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

В.1 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 56 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлд үндэслэн нийт 18.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

²⁵ 59.10.1. тендер шалгаруулалт, эсхүл захиалагчийн шийдвэрийг хэсэгчлэн, эсхүл бүхэлд нь хүчингүй болгох, өөрчлөлт оруулах;

²⁶ 59.10.2. зөрчлийг арилган, тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг даалгах;

²⁷ 14.6. Дараах нөхцөлийн аль нэг үүссэн бол захиалагч тендерийн баталгааг улсын орлого болгоно:

14.6.3. санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

²⁸ 5.13. Хуулийн 14.6.3-т заасан нөхцөл үүссэн тухай шийдвэрийг хүлээн авсан захиалагч гомдол гаргагчийн 20 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй тендерийн баталгааг бүхэлд нь, түүнээс дээш үнийн дүнтэй тендерийг баталгааг хуулийн 14.7-д заасан үнийн дүнгээр Төв төрийн сангийн дансанд төвлөрүүлж, улсын орлого болгоно.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа ч хэрэгжилт хангалтгүй байна.

Аймгийн төсвийг тодотгосон ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 53 дугаар тогтоолоор баталсан 67 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэн баталж, бүрэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт 92.1 хувьтай байгаа нь өмнөх оны гүйцэтгэлээс 24.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-13: ТАХ-ний хэрэгжилт

Он	Төлөвлөсөн төсөл, арга хэмжээний тоо	Гүйцэтгэл			Хэрэгжилтийн хувь
		Хэрэгжиж дууссан	Хэрэгжилт дутуу	Хэрэгжээгүй	
2024	86	50	8	28	67.4
2025	67	56	8	3	92.1

Төлөвлөсөн хугацаанд хэрэгжиж амжаагүй 7 төсөл, арга хэмжээнүүд дараах шалтгаанаар хэрэгжиж дуусаагүй байна.

- Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах /гэрээний дүн 8,649.3 сая төгрөг/ болон Төв цэвэрлэх байгууламжаас хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэрт дэд бүтэц татах /гэрээний дүн 717.7 сая төгрөг/ ажил санхүүжилт олгогдоогүй, удааширсан;
- Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийн шинэчлэл /гэрээний дүн 2,169.4 сая төгрөг/, Цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах камержуулалт /гэрээний дүн 30.5 сая төгрөг/, Сайнцагаан сумын төрийн нэг цэгийн үйлчилгээний төвд тоног төхөөрөмж /гэрээний дүн 464.1 сая төгрөг/, Арвижих багийн ахмадын төв шинээр барих /гэрээний дүн 97.8 сая төгрөг/, Дундговь аймгийн 15 сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах /гэрээний дүн 737.0 сая төгрөг/, Цахим хаягжилт, 360° зураг /гэрээний дүн 225.0 сая төгрөг/ ажлууд гүйцэтгэгч компани хугацаандаа гүйцэтгэж амжаагүй шалтгаанаар бүрэн дуусаагүй он дамжсан байна.

Харин Цагаандэлгэр сумын хөгжлийн төвийн шинэ барилга /төсөвт өртөг 498.4 сая төгрөг/ зураг төсөвт шинэчлэлт хийгдсэн, Дэрэн сумын төрийн албан хаагчдын байрны их засвар гадна шугам сүлжээ /төсөвт өртөг 89.2 сая төгрөг/, Хөдлөх хөрөнгийн их засвар /төсөвт өртөг 30.0 сая төгрөг/-ын ажил зураг төсөв, ТЭЗҮ байхгүй, худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон шалтгаанаар хэрэгжээгүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх, үр өгөөж буурах сөрөг үр дагавартай байна.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа ажлууд гэрээний хугацаанд хэрэгжихгүй байгаа нь холбогдох хууль, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөснөөс худалдан авах ажиллагаа хойшлогдож хугацаа алдах, гүйцэтгэгчээс шалтгаалж, өнгөрсөн оны сүүлд санхүүжилтийг зогсоосонтой холбоотой байна.

Иймд худалдан авах ажиллагааг цаг адалгүй зохион байгуулах, төсөл, арга хэмжээг гэрээний хугацаанд бүрэн гүйцэтгэх чадамжтай этгээдийг сонгон шалгаруулахад анхаарах нь зүйтэй. Мөн гүйцэтгэгчээс шалтгаалан гэрээний хугацаанд хэрэгжиж дуусгаагүй тохиолдолд тендерийн баримт бичгийн “Гэрээний тусгай нөхцөл”-д заасан хэмжээгээр алдангийг тооцож байх шаардлагатай байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4²⁹-т заасны дагуу Аймгийн засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн А/957 тоот захирамжаар орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 9 төсөл, арга хэмжээг сумдын Засаг дарга нарт эрх шилжүүлснээс дараах ажлууд тайлан ондоо хэрэгжиж дууссан байна. Үүнд:

- ★ Өвс тэжээлийн агуулахын барилга /Өндөршил сум/
- ★ Төрийн үйлчилгээний автомашин Адаацаг сум/

²⁹ Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шүүд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

- ★ Хулд сумын төрийн албан хаагчдын байрны их засвар
- ★ Эрдэнэдалай сумын ЕБС-ийн дээврийн засвар

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн санхүүжүүлж, гүйцэтгэл 63.9 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 33,612.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 29,532.1 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 67 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн ИТХ-ын 2025 оны 53 дугаар тогтоолоор баталжээ. Үүнээс 65 төсөл, арга хэмжээг 30,479.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Ажлын гүйцэтгэлд үндэслэн 54 төсөл, арга хэмжээнд 18,889.7 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэлд 63.9 хувь байна.

Хүснэгт-14: Санхүүжилтийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал /сая төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	Гэрээний үнэ	Тайлант онд санхүүжих	Олгосон санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь
1	Өмнөх оноос шилжсэн	5,850.8	5,846.3	5,634.5	4,767.2	84.6
2	Барилга, байгууламж	14,796.9	14,597.3	12,748.6	5,116.8	40.1
3	Тоног төхөөрөмж	2,805.6	2,801.7	2,805.6	2,583.5	92.1
4	Хөтөлбөр, төсөл	3,741.1	1,253.9	3,394.1	1,815.8	53.5
5	Их засвар	6,418.5	5,979.9	4,949.3	4,606.3	93.1
	Дүн	33,612.9	30,479.1	29,532.1	18,889.6	63.9

Тайлант онд хэрэгжүүлэхээр баталсан их засварын төсөл, арга хэмжээний санхүүжилт 93.1 хувь буюу хамгийн өндөр байгаа бол барилга, байгууламжийн ажлын санхүүжилт хамгийн бага буюу 40.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Харин өмнөх оноос шилжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт 84.6 хувь байна.

Төсөвт өртөг өндөр дараах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт дутуу олгосон нь төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд нөлөөлсөн байна.Тухайлбал:

- Камерын нэгдсэн удирдлагын төвийн байрны их засварын төсөл, арга хэмжээ- 180.5 сая төгрөг;
- Дундговь аймгийн 15 сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах төсөл, арга хэмжээ- 147.4 сая төгрөг;
- Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах төсөл, арга хэмжээ- 5,623.2 сая төгрөг;
- Төв цэвэрлэх байгууламжаас Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэрт дэд бүтэц татах төсөл, арга хэмжээ- 359.5 сая төгрөг;
- Дулаан дамжуулах шугамын ажил, 4 дүгээр хэсэг /Сайнцагаан сум/ төсөл, арга хэмжээ- 840.0 сая төгрөгийг Сангийн яамнаас санхүүжилтийг зогсоосон, комисс ондоо багтааж хүлээж авч амжаагүй, гүйцэтгэгчээс шалтгаалж ажил дуусаагүй зэрэг шалтгаанаар санхүүжилтийг тайлант онд олгоогүй байна.

Мэргэжлийн байгууллагаас захиалагчийн хяналт хийгддэггүй тоног төхөөрөмж бэлтгэх, шууд худалдан авалтаар гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, хүлээн авах комиссын гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тайлант онд хөрөнгө оруулалтын 56 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, хүлээн авах комиссыг холбогдох хууль, журмын дагуу томилж, ашиглалтад хүлээн авч, гэрээг дүгнэсэн байна.

Аудитын явцад зарим төсөл, арга хэмжээг түүвэрлэн гүйцэтгэлтэй байдалтай газар дээр нь танилцахад чанаргүй тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн, комиссын гишүүд ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавиагүй, комисс бүрэлдэхүүн дутуу ажилласан, актад дараа нь нөхөж гарын үсгээ зурсан зэрэг дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Хүнд даацын автомашины жин хэмжигч зөөврийн авто пүү” төсөл, арга хэмжээний хүрээнд аймгийн Авто тээврийн газарт нийлүүлэгдсэн пүүг мэргэжлийн байгууллагаар

баталгаажуулаагүй байна. Комисс хүлээж авахад хийсэн туршилтаар 4-5 тонн зөрүүтэй зааж байсан талаар комиссын гишүүдтэй хийсэн ярилцлагаар нотлогдсон. Гэвч комисс хүлээж авсан байна. Жин зөрүүтэй заадаг тул хүлээж авснаас хойш нэг ч удаа ашиглаагүй байдалтай байна. Тус пүүг 30.8 сая төгрөг буюу зах зээлийн үнээс хэт өндөр үнээр нийлүүлэгдэж төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан байна.

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт техник сэтгэлгээг хөгжүүлэх, суурь ойлголтыг олгох зорилгоор "Unitel Hub" өрөө байгуулах төсөл, арга хэмжээг 19.2 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн байна. Ажлын даалгаврын дагуу хийгдээгүй зөрчил илэрлээ. Үүнд: Паркетан шал хийгээгүй, халуун хүйтнээр үлээдэг кондишныг дутуу нийлүүлсэн. Ханыг блокоор өрөхөөр тусгасныг рам зангидаж гоёлын хавтангаар гүйцэтгэсэн байна. Хүлээж авах комисс ажлын даалгаврын дагуу хийгдээгүй, тоног төхөөрөмж дутуу нийлүүлсэн байхад хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон нь комиссын гишүүд үүргээ хэрэгжүүлээгүй, ашиглагч байгууллага болон эрх бүхий холбогдох албан тушаалтнууд хяналт тавиагүйгээс шалтгаалсан байна.
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хөгжлийн бэрхшээлтэй хүний өрөө тохижуулах, Цахим хяналтын өрөөний тоног төхөөрөмжөөр хангах 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулсан техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгээгүй. Хүлээж авах ажлын хэсэг болон холбогдох албан тушаалтнууд хяналт тавиагүй.

Дээрх зөрчлүүдийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг хүлээж авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тухайн мэргэжлийн албан хаагчийг оролцуулах, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, комиссын гишүүд эрх, үүргээ ухамсарлан ажлын даалгаврын дагуу хийгдсэн болон техникийн тодорхойлолт, шаардлагыг хангаж байгаа эсэхийг тулган баталгаажуулж, шийдвэрээ бие даан гаргахад анхаарах нь зүйтэй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцааг холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт заасны дагуу байршуулсан эсэхийг тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд бүрэн хэрэгжиж, гэрээг дүгнэн эцсийн санхүүжилтийг олгосон 14 төсөл, арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцаа 112.8 сая төгрөгийг огт байршуулаагүй; /Дэлгэрэнгүйг Хавсралт-3.-аас үзнэ үү./
- Аймгийн төвийн нэгдсэн камержуулалтын ажлын ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцааг хууль, журам, тендерийн баримт бичигт гэрээний үнийн дүнгийн 5 хувиар буюу 92.3 сая төгрөгийг байршуулахаар тусгасан боловч 86.1 сая төгрөг буюу 7.2 сая төгрөгөөр дутуу байршуулсан;
- Халаалтын зуухнуудын шинэчлэлийн ажлын чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны барьцаа 40.5 сая төгрөгийг байршуулсан боловч ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацаа дуусахаас өмнө буюу 2025 оны 8 дугаар сарын 8-ны өдөр чөлөөлж гүйцэтгэгчид олгосон;

Дээрх зөрчлүүд нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5³⁰, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 4.2.2.5³¹-д заасныг тус тус хэрэгжүүлээгүй

³⁰ Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно.

³¹ Төсөл, арга хэмжээний техник, технологийн хяналтын зардал болох захиалагчийн хяналт, зохиогчийн хяналтын зардлыг захиалагчийн техник хяналтын дансанд, чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгшрүүлэх хугацааны санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд, зураг төслийн үнэ, нормчлолын сангийн зардлыг тус тусын дансанд холбогдох гэрээ, баримт бичиг, акт зэргийг үндэслэн шилжүүлэх;

бөгөөд өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан байна. Иймд зарим чанарын баталгааны барьцааг нөхөн байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүллээ.

Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байгаа төсөл, арга хэмжээний чанарын баталгаат хугацааны барьцаа буюу ашиглалтад тохируулах, зүгширүүлэх хугацааны барьцааг хууль, журам, тендерийн баримт бичигт заасны дагуу байршуулж, гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулан, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж байх нь зүйтэй байна.

Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулаагүй, ил тод мэдээлээгүй байна.

Монгол Улсын үндэсний стандартад /MNS 7023:2023/ заасны дагуу улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжих инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын ажил бусад бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбар байршуулах, тэдгээрийн нэгдсэн загвар, аргачлалыг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2023 оны С/49 дүгээр тушаал баталсан байна. Дээрх загвар, аргачлалын дагуу Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах ажлын мэдээллийн самбарыг стандартад тавигдах шаардлагын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн байна. Харин бусад инженерийн барилга байгууламжийн барилгын ажил, гадна тохижилтын болон бүтээн байгуулалтын ажилд мэдээллийн самбар байршуулаагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.2³² дэх хэсэгт заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд төсвийн хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээнд хэрэглэх мэдээллийн самбарыг холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу байршуулсан эсэхэд захиалагч хяналт тавих шаардлагатай байна.

Барилга байгууламжид давхардсан тоогоор зохиогчийн хяналтыг 43 удаа, захиалагчийн техникийн хяналтыг 49 удаа хэрэгжүүлж, акт, фото зургаар баталгаажуулсан байна.

Аймгийн Засаг дарга 2025 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажилд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраар захиалагчийн хяналт хийлгэхээр гэрээ байгуулжээ.

Тайлант онд Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас гэрээний дагуу өмнөх оноос шилжин хэрэгжсэн 7, шинээр 2025 онд санхүүжүүлж хэрэгжүүлсэн 20 барилга, байгууламж, засвар, тохижилтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд давхардсан тоогоор 49 удаагийн захиалагчийн хяналтыг хийж, тайлан, фото зургаар баримтжуулсан байна. Захиалагчийн хяналтын зардалд 256.0 сая төгрөгийг гэрээний дагуу олгосон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд хяналт, шалгалт хийгээгүй байна.

Иймд Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.1.3³³, 5.2.4³⁴-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд хяналт, шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгч, илэрч байгаа алдаа зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 04 тоот захирамжаар орон нутгийн төсвийн 2025 онд хийгдсэн хөрөнгө оруулалтад хяналт тавих ажлын хэсэг байгуулсан байна. Ажлын хэсэгт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт хийж зөвлөгөө өгч ажилласан байна.

³²Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.6.10, 8.6.11-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаархи иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байрлуулах;

³³ 5.1.3. төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдал;

³⁴ 5.2.4. төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих;

В.2 Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 707.7 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын дансанд бүртгээгүй, зориулалтын дагуу ашиглах боломжгүй хөрөнгө бэлтгэж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон зарим хөрөнгийг хүлээн авснаас хойш огт ашиглаагүй байна.

Аудитын явцад аудитын баг Сайнцагаан сумын нутагт дэвсгэрт хэрэгжсэн барилга байгууламж, их засварын 11, тоног төхөөрөмж бэлтгэсэн 10 төсөл, арга хэмжээг түүвэрлэн гүйцэтгэл, ашиглалтын байдалтай газар дээр нь танилцахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- “Халаалтын зуухнуудын шинэчлэл” төсөл, арга хэмжээг гүйцэтгэгчтэй 809.4 сая төгрөгийн гэрээ байгуулан хэрэгжүүлж, 6 ширхэг зуух нийлүүлэгдсэн байна. Гүйцэтгэгч зуухнуудыг хүлээлгэн өгөхдөө техникийн тодорхойлолтод заагдсан үзүүлэлт, шаардлагыг хангаж буй эсэхийг нотлох баримт болох техникийн паспорт, туршилт хийгдсэн мэдээлэл, ашиглалтын заавар, бусад материал, бичиг баримтыг захиалагч талд өгөөгүй, гарал үүсэл тодорхойгүй зуух нийлүүлсэн байна. Тиймээс шаардлага хангасан зуух нийлүүлсэн эсэхэд дүгнэлт өгөх боломжгүй байна. Зуухнууд ажиллаж эхэлснээс хойш 2 сарын дараа экран хоолой цоорох, ул ширэм сорогдох зэргээр эвдрэл гэмтэл гарч эхэлсэн байна. Чанаргүй хөрөнгө бэлтгэж хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³⁵-д заасан зарчмыг зөрчиж байна.
- “Хүнд даацын автомашины жин хэмжигч зөөврийн авто пүү” төсөл, арга хэмжээний хүрээнд аймгийн Авто тээврийн газарт нийлүүлэгдсэн пүүг зөрүүтэй хэмждэг шалтгаанаар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт “Насанд хүрээгүй хүүхдээс мэдүүлэг авах” өрөөг хяналтын камерыг холбоогүй гэдэг шалтгаанаар огт ашиглаагүй байна.

Иймд техникийн тодорхойлолтод заасан үзүүлэлтийг хангах, гарал үүсэл тодорхой, чанартай зуухаар солиулах, мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан пүүгээр солиулах албан шаардлага, бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүлээ.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгээгүй зөрчил байсаар байна.

Аудитын явцад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг НББ-д тусган тайлагнасан байдлыг түүвэрлэн тулгаж үзлээ. Түүвэрлэлтээр нийт 10,650.2 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагын хөрөнгийн дансанд орлого авч, санхүүгийн тайланд тусгахаас 9,942.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн, 707.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгагдаагүй байна. Үүнд:

- Луус сумын соёлын төвийн барилгын их засвар /гэрээний дүн 695.6 сая төгрөг/;
- “Ногоон Дундговь” төслийн хүрээнд Мандалын гэгээ ОНӨААТҮГ-т нийлүүлэгдсэн 12.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй усжуулах тоног төхөөрөмжийг орон нутгийн өмчид бүртгээгүй байна.

Аудитын явцад Луус сумын соёлын төвийн барилгын их засварын ажлыг байгууллагын баланст сайжруулалтаар бүртгүүлж, зөрчлийг арилгалаа.

Төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, эвдрэл гэмтэл үүсэх эрсдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.5 дэх хэсгийн 5.5.1, 5.5.2, 5.5.3³⁶-т заасан хөрөнгийг бүртгэхтэй

³⁵ Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

³⁶ 5.5.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу төрийн болон орон нутгийн өмч байх буюу төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг

холбоотой заалтуудыг хэрэгжүүлж ажиллахгүй байна. Хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж, зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарах талаар аймгийн Засаг даргад зөвлөмж хүргүүллээ.

Иймд хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг комисс хүлээн авсан даруйд хөрөнгийн бүртгэлд бүртгэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж байх шаардлагатай байна.

Өмнөх аудитаар тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 90.9 хувиар биелсэн байна.

Өмнөх аудитаар Аймгийн Засаг дарга, Баянжаргалан сумын Засаг дарга, Сайнцагаан сумын Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт нийт 3 заалт бүхий зөвлөмж, 7 албан шаардлага, 1 хариуцлага тооцох албан шаардлагын хүргүүлсэн. Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг тулган шалгахад аймгийн Засаг даргад өгсөн 3 зөвлөмж, хариуцлага тооцох албан шаардлага, 6 хугацаатай албан шаардлагын хэрэгжүүлэн заасан хугацаанд хариу ирүүлж, биелэлт 90.9 хувьтай байна.

Харин хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг бүртгэх албан шаардлагыг хэрэгжилтийг биелүүлээгүй байна. Хэрэгжээгүй талаар Орон нутгийн өмчийн газраас тодруулахад:

- “Боловсрол, соёлын үйлчилгээний дунд оврын автобус” /төсөвт өртөг 224.9 сая төгрөг/ төсөл, арга хэмжээний асуудлыг Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байгаа учир данс бүртгэлд тусгах ажил хүлээгдэж байгаа;
- “ШШГГ-ын албан хэрэгцээнд нийлүүлэгдсэн автомашин” /төсөвт өртөг 24.9 сая төгрөг/, мөн “ШШГГ-ын алба хаагчийн хөгжлийн төвийн барилгын засварын тохижилт” /төсөвт өртөг 20.0 сая төгрөг/ төсөл, арга хэмжээг бүртгүүлэхээр дээд шатны байгууллага ШШГЕГазарт 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/900 тоот албан бичгээр бүртгүүлэх хүсэлтээ өгсөн боловч данс бүртгэлд тусгах зөвшөөрөл ирээгүй гэсэн шалтгаанаар бүртгэж аваагүй байна.

Иймд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон, хөрөнгө оруулалтыг хүлээн авах комиссын шийдвэр гарсан даруй ашиглагч байгууллагын дансанд бүртгэж хэвших нь зүйтэй байна.

байнгын ашиглалтад хүлээн авсан, тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон зураг төсөл, ТЭЗҮ-г захиалагч хүлээн авсны дараа төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлнэ;

5.5.2.Энэ журмын 5.5.1-д заасан хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид бүртгүүлэх чиг үүргийг захиалагчийн өмчийн асуудал хариуцсан нэгж (ажилтан) хэрэгжүүлэх бөгөөд өмчид бүртгүүлэхийг тодорхойлох урьдчилсан маягтыг бөглөн цахим системээр гүйцэтгэлийн санхүүжилтийн хүсэлтэд хамт ирүүлж, цахим системийн өмчийн санд мэдээллийн санг бүрдүүлнэ;

5.5.3.Өмчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлсон шийдвэрийн дагуу төрийн өмчийн бүртгэлийн нэгдсэн системд өмчийн бүртгэл хийгдсэнээр цахим систем дэх урьдчилсан бүртгэлийн мэдээлэл баталгаажиж өмчийн мэдээллийн санд бүртгэгдэнэ.



Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Үүнд:

- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хөрөнгийн бус шинжтэй, арга хэмжээг төлөвлөн баталж, зарцуулж байгаа нь холбогдох хууль, журмыг зөрчиж байна.
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль, журмын шаардлагад нийцүүлээгүй төлөвлөсөн зөрчил буурахгүй байна.
- ✓ Тоног төхөөрөмж бэлтгэх төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, үзүүлэлт, төсөвт өртгийг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн боловсруулахгүй, түүнд тавих хяналт сул байгаа нь чанаргүй хөрөнгө бэлтгэх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэлийг бий болгож байна.
- ✓ Зарим сумд орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, цахим системээр илгээгээгүй байна.
- ✓ “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар”-ыг зөрчин 100.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.
- ✓ Аймаг, сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойш зохион байгуулсан байна.
- ✓ Тайлант онд нийтдээ 5.9 сая төгрөгийн тендерийн баталгааг улсын орлого болгож, төрийн сангийн тендерийн баталгааны дансанд төвлөрүүлсэн байна.
- ✓ Мэргэжлийн байгууллагаас захиалагчийн хяналт хийгддэггүй тоног төхөөрөмжийн болон шууд худалдан авалтаар гүйцэтгэж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, хүлээн авах комиссын гишүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 56 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлд үндэслэн нийт 18.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.
- ✓ Барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу хийж байршуулаагүй, ил тод мэдээлээгүй байна.
- ✓ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 707.7 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын дансанд бүртгээгүй, зөрчлийг давтан гаргасаар байна.
- ✓ Зориулалтын дагуу ашиглах боломжгүй хөрөнгө бэлтгэж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.



Зөвлөмж

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа барилга байгууламжийн төсөл, арга хэмжээний мэдээллийн самбарыг стандартын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэхэд хяналт тавих;
2. Хяналтын камерын холболтыг хийгээгүй шалтгаанаар огт ашиглаагүй байгаа Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын "Насанд хүрээгүй хүүхдээс мэдүүлэг авах" өрөөг зориулалтын дагуу ашиглаж, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх;
3. Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлсэн "Ногоон Дундговь" төслийн хүрээнд нийлүүлэгдсэн усалгааны систем холбогдох байгууллагын дансанд бүртгэж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулан, хяналт тавьж ажиллах;

Дэрэн, Дэлгэрцогт сумдын Засаг дарга нарт:

1. Сумын орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээг сумын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталж, хэрэгжилтийг холбогдох этгээдэд тайлагнаж хэвиших;



Шалгагдагч байгууллагын санал тайлбар



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

С.Бундмаагийн өргөн чөлөө 2-211 1007, Т.дугаар байр,
Сайнцагаан сум, Дундговь аймаг, 48060 Утас: 7059 2355
Цахим иргэд: info@dulgov.gov.mn,
Цахим хуудас: www.dulgov.gov.mn

2026.05.10 № 01/БС
Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Дээрх тайлбартай төсөл, арга хэмжээг холбогдох хууль журмын дагуу зөрчилд тооцохыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа тул нягталж үзэхийг хүсье.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ц.АРИУНБАЯР



Тайлангийн төсөлд санал хүргүүлэх тухай

Орон нутгийн төсвийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын тайлангийн төсөлд хариу тайлбар хүргүүлж байна. Үүнд:

1. Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр зардал үр дүнтэй шинжилгээ болон менежментийн төлөвлөгөө боловсруулсан судалгааны шатанд явж буй бөгөөд ажлын хэсэг байгуулж дээрх шинжилгээ, төлөвлөгөөг хэлэлцүүлэн аймгийн Засаг даргаар батлуулахаар төлөвлөж байна. дээрх судалгааг цахимаар хүргүүлэв. Мөн Цагаандэлгэр сумын хөгжлийн төвийн шинэ барилга нь ашиглалтад орсон үеэс хувийн хэвшил үйлчилгээний орлогоор зардлаа санхүүжүүлэх хэлбэрээр төлөвлөсөн болно.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт бус орон нутгийн төсвийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт нэртэйгээр дэд хөтөлбөрүүдийг оруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн баталсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

3. Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь хэсэгт "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно." гэж заасны дагуу тоног, төхөөрөмжийн хувьд гэрээ баталгаажуулахад 2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр баталгааны хуудсаар чанарын баталгааг ханган ажиллаж байна.

4. Халаалтын зуухнуудын шинэчлэл ажлын хүрээнд нийлүүлсэн зуухнуудыг холбогдох хууль, журмын хүрээнд чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар шаардлагатай зуухыг шинэчлүүлэх, засварлуулахаар ажиллаж байна.

5. Хүнд даацны авто пүүг хүлээж авах үед зөрчил илрээгүй бөгөөд ашиглагч байгууллагаас ямар нэг гомдол, санал ирүүлээгүй. Аудитын явцад тус зөрчлийг мэдсэн бөгөөд мөн чанарын баталгаат хугацаанд гүйцэтгэгч байгууллагаар зөрчлийг арилгуулах арга хэмжээ авна.

4826230889

Дундговь аймгийн Засаг даргаас ирүүлсэн тайлбарт хариу өгөх Аудитын газрын тайлбар:

Тайлбар-1

Тайлангийн төсөлд санал ирүүлсэн албан бичгийг судлаад дээрх 5 асуудлыг зөрчлийн бүртгэлд хэвээр үлдээж, албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Хавсралт-1 Хөрөнгө оруулалтаар 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	2021-2025 оны үндсэн чиглэлийн заалт	2024-2028 оны ЗДҮАХ-ны заалт	Зураг төсөв эсэх	Магадлалын дүгнэлттэй эсэх	Техникийн тодорхойлолттой эсэх	Ажлын даалгавартай эсэх	Урсгал зардлын тооцоо хийгдсэн эсэх
1	Спорт, тоглоомын талбай байгуулах	300,000,000	3.4.1.1	1.1.2.9	Тийм	Үгүй			
2	Төрийн үйлчилгээний авто бааз байгуулах	800,000,000		1.1.3.7				Үгүй	
3	Ёслол хүндэтгэлийн өргөөний засвар, шаардлагатай тоног төхөөрөмж	200,000,000			Тийм	Үгүй			
4	Өвс тэжээлийн агуулахын барилга /Өндөршил сум/	300,432,901	8.3	4.2.1.5	Тийм	Үгүй			Үгүй
5	Багийн төвийн барилгын засвар /Адаацаг сум, Сүм баг/	130,287,879	6.1.1.7	2.1.1.3	Үгүй				
6	Хөгжлийн төвийн шинэ барилга /Цагаандэлгэр сум/	348,865,761	2.4.5.1	3.9.1.4	Тийм	2025.11.27			Үгүй
7	Ахмадын өргөөний барилга /Говь-Угтаал сум/	150,000,000	3.4.2.3	3.6.1.7	Тийм	2025.10.07			Үгүй
8	Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэр байгуулах	8,650,000,000	4.2.2.3	1.1.2.4	Тийм	2025.07.30			Үгүй
9	Боловсрол шинжлэх ухааны газрын дээвэр, пасадны засвар	175,875,460	5.1.1.1	2.1.1	Тийм	Үгүй			
10	Төв цэвэрлэх байгууламжаас Хог хаягдал шатааж дулааны эрчим хүч боловсруулах үйлдвэрт дэд бүтэц татах	128,527,498	4.2.2.2	1.1.2.7	Тийм	2025.07.30			
11	Иргэдийн гамшгаас хамгаалах сургалт арга зүйн танхимын өргөтгөл	82,000,000	7.2.1.2	2.4.1	Үгүй				
12	Хүүхэд залуучуудын хөгжлийн төвийн гадна пасадны засвар /Говь-Угтаал сум/	190,000,000	5.1	3.7.1	Тийм	Үгүй			
13	Сургуулийн барилгын засвар /Луус сум/	339,532,814	2.1.2.1	3.1.1.7	Тийм	2025.02.26			
14	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийн шинэчлэл	2,500,000,000	8	1.1.2.9	Тийм	2025.05.12			Үгүй
15	Дулаан дамжуулах шугамын ажил, 3 дугаар хэсэг /Сайнцагаан сум/	565,544,362	3.5.1.3	1.1.2.6	Тийм	2025.09.10			
16	Дулаан дамжуулах шугамын ажил, 4 дүгээр хэсэг /Сайнцагаан сум/	1,583,895,090	3.5.1.3	1.1.2.6	Тийм	2025.09.10			
17	Авто тээврийн газрын дэд бүтцийн засвар	15,000,000	4.2.2	1.1.2.7				Тийм	
18	Халаалтын зуухнуудын барилгын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/	381,851,356	3.5.1	1.1.2.6	Тийм	2025.08.29			Үгүй

19	Мал эмнэлэгийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж	75,000,000	8.3.4.12	4.2.1.11			Тийм	
20	Сайнцагаан сумын Эрдмийн далай сургуульд мэдээлэл зүйн "SMART" кабинет байгуулах	123,000,000	2.1.2	3.1.1.1			Тийм	
21	Халаалтын зуухнуудын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/	821,713,802	4.2.2	1.1.2.6			Тийм	
22	Төрийн үйлчилгээний автомашин /Баянжаргалан сум/	50,000,000	5.1	2.1.1			Тийм	
23	Төрийн үйлчилгээний автомашин /Адаацаг сум/	150,000,000	5.1	2.1.1			Тийм	
24	Нийгмийн үйлчилгээний автомашин /ХБИТ/	85,000,000	5.1	3.8.1.2			Тийм	
25	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүний өрөө тохижуулах	14,200,000	7.3	3.8.1.1			Тийм	
26	Стандарт хэмжил зүйн хэлтсийн албан хэрэгцээнд даралтны аппарат шалгах этолан, лабораторын татах шүүгээ	27,000,000	5.1.1.1	2.1.1			Тийм	
27	Хүнд даацгийн автомашины жин хэмжигч зөөврийн авто пүү	40,000,000	8.1.1.1	1.1.1.5			Тийм	
28	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн албан хэрэгцээнд тоног төхөөрөмж	142,500,000	5.1.1.1	2.1.1			Тийм	
29	Аймгийн төвийн 35/6 кВ дэд станц 10.3МВт суурилагдсан хүчин чадлыг 16.3МВт болгож нэмэгдүүлэх тоног төхөөрөмж	500,000,000	4.2.2.1	1.1.4.5			Тийм	
30	Аймгийн төвийн цахилгааны нөөц эх үүсвэрийг нэмэгдүүлэх 500кВт хүчин чадал бүхий дизель генератор	290,000,000	4.2.2	1.1.4.1			Тийм	
31	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын цахим хяналтын өрөөний тоног төхөөрөмж	16,937,000	7.3	2.3.1.2				Тийм
32	Онцгой байдлын албан хэрэгцээнд эрэн хайх аврах ажиллагаанд ашиглах дрон	42,000,000	7.2.1.4	2.4.1.3			Тийм	
33	ЕБС-ийн физикийн хичээлийн цогц багаж /10 сургууль/	120,000,000	2.1.2.7	3.1.1.1			Тийм	
34	Аймгийн төвийн халаалт, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, засварын ажлын материал	400,000,000	4.2.2	1.1.2.7			Тийм	
35	Усан эмчилгээний тоног төхөөрөмж /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв/	13,700,000	2.4.2.1.5	3.8.1.2			Тийм	
36	Зөөврийн хурд хэмжигч багаж	50,000,000	7.3.1.3	2.3.1.4			Тийм	
37	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт "Unitel Hub" өрөө тохижуулах	19,170,000	2.4.5.1	3.7.1				Тийм

38	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт "Насанд хүрээгүй хүүхдээс мэдүүлэг авах" өрөө тохижуулах	18,681,400	7.2.2.3	3.7.1.1			Тийм	
39	Эрдэнэдалай сумын шинэ цэцэрлэгийн зөөлөн эдлэл	57,414,000	2.1.1	3.1.1			Тийм	
40	"Оюунлаг Дундговь" хөтөлбөр	300,000,000	3.3.1.1	3.1.1.1				
41	"Эрүүл Дундговь" хөтөлбөр	300,000,000	2.2	3.2.1.1				
42	"Цахим Дундговь" хөтөлбөр	500,000,000	5.3.1.1	2.2.1.1				
43	"Ногоон Дундговь" төсөл	200,000,000	6.2.2	5.1.1.1				
44	"Хоггүй Дундговь" төсөл	400,000,000	3.3.1.1	5.1.1.2				
45	"Нээлттэй Дундговь" хөтөлбөр	100,000,000	3.3.1.1	1.1.1.1				
46	"Мал аж ахуйг дэмжих" хөтөлбөр	550,000,000	8.3.3	4.2.1.1				
47	"Аялал жуулчлалыг дэмжих" хөтөлбөр	300,000,000	8.2	4.3.1.1				
48	"Хүний нөөцийг дэмжих" хөтөлбөр	1,000,000,000	5.4.1.3	2.1.1.1				
49	"Сүү" хөтөлбөр	300,000,000	2.2	3.2.1.1				
50	Цахим хаягжилт, 360° зураг	250,000,000	5.3.1.1	1.1.1.1			Тийм	
51	Дундговь аймаг-Бүгд найрамдах Киргиз улсын Баткен хот хоорондын санамж бичгийн хүрээнд хэрэгжүүлэх Ногоон байгууламж нэмэгдүүлэх	100,000,000	6.2.2	5.1.1.1			Үгүй	
52	Дундговь аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө	847,000,000	8.1.1	1.1.1.6			Тийм	
53	Хулд сумын төрийн албан хаагчдын байрны их засвар	802,595,218	5.1	2.1.1.5	Тийм	2024.10.29		
54	Дэрэн сумын төрийн албан хаагчдын байрны их засвар	414,952,764	5.1	2.1.1.5	Тийм	2024.11.22		
55	Дэрэн сумын төрийн албан хаагчдын байрны их засвар гадна шугам сүлжээ	89,221,689	5.1	2.1.1.5	Тийм	2024.11.22		
56	Сургуулийн барилгын их засвар /Дундговь, Хулд сум/	1,415,548,605	2.1.2.1	3.1.1.7	Тийм	2023.12.13		
57	Спорт заалны барилгын дуусгал /Дундговь, Говь-Угтаал сум/	1,190,869,872	3.4.1.1	3.3.1.6	Тийм	2026.06.16		
58	Спорт заалны барилгын дуусгал /Дундговь, Говь-Угтаал сум/ Гадна шугам сүлжээний ажил	254,833,633	3.4.1.1	3.3.1.6	Тийм	2025.06.10		
59	Говийн ирээдүй цогцолбор сургуулийн дотуур байрны засварын ажил	542,780,237	2.1.2.1	3.1.1.7	Тийм	2025.02.26		
60	Сайнцагаан сумын 5-р цэцэрлэгийн барилгын засварын ажил	278,520,430	2.1.1.1	3.1.1.7	Тийм	2025.05.10		
61	Мандал сургуулийн гадна тохижилт, авто зогсоол	182,949,563	2.1.2	3.1.1	Тийм	Үгүй		

62	Сайнцагаан сумын 7-р цэцэрлэгийн барилгын засварын ажил	152,894,475	2.1.1.1	3.1.1.7	Тийм	Үгүй			
63	Баянжаргалан сумын дотуур байрны их засвар	478,657,710	2.1.2.1	3.1.1.7	Тийм	2024.09.09			
64	Сургуулийн барилгын их засвар /Эрдэнэдалай сум, 3-р байр/	296,035,701	2.1.2.1	3.1.1.7	Тийм	2024.02.02			
65	Эрдэнэдалай сумын ЕБС-ийн дээврийн засвар	263,935,098	2.1.2.1	3.1.1.7	Тийм	Үгүй			
66	Хөдлөх хөрөнгийн их засвар	94,321,266	2.2.2.2	1.1.3.7	Үгүй				

Хавсралт-2 Тоног төхөөрөмж бэлтгэх төсөл, арга хэмжээний мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Техникийн тодорхойлолттой эсэх	Ажлын даалгавартай эсэх	Техникийн тодорхойлолтыг боловруулсан, хянасан этгээд тодорхойгүй	Техникийн тодорхойлолтыг боловруулсан этгээд тодорхойгүй	Техникийн тодорхойлолтыг хянасан этгээд тодорхойгүй	Төсвийн ерөнхийлөн захирагчаар батлуулаагүй
1	Халаалтын зуухнуудын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/	821,713,802	Тийм		Тийм			
2	Төрийн үйлчилгээний автомашин /Баянжаргалан сум/	50,000,000	Тийм		Тийм			Тийм
3	Төрийн үйлчилгээний автомашин /Адаацаг сум/	150,000,000	Тийм		Тийм			Тийм
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газарт хөгжлийн бэрхшээлтэй хүний өрөө тохижуулах	14,200,000	Тийм		Тийм			
5	Хүнд даацгийн автомашины жин хэмжигч зөөврийн авто пүү	40,000,000	Тийм		Тийм			
6	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн газрын цахим хяналтын өрөөний тоног төхөөрөмж	16,937,000		Тийм	Тийм			
7	ЕБС-ийн физикийн хичээлийн цогц багаж /10 сургууль/	120,000,000	Тийм		Тийм			
8	Мал эмнэлэгийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж	75,000,000	Тийм			Тийм		
9	Сайнцагаан сумын Эрдмийн далай сургуульд мэдээлэл зүйн "SMART" кабинет байгуулах	123,000,000	Тийм			Тийм		
10	Усан эмчилгээний тоног төхөөрөмж /Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв/	13,700,000	Тийм			Тийм		
11	Онцгой байдлын албан хэрэгцээнд эрэн хайх аврах ажиллагаанд ашиглах дрон	42,000,000	Тийм				Тийм	
12	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт "Unitel Hub" өрөө тохижуулах	19,170,000		Тийм				Тийм
13	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газарт "Насанд хүрээгүй хүүхдээс мэдүүлэг авах" өрөө тохижуулах	18,681,400	Тийм					Тийм

Хавсралт-3 Төсөл, арга хэмжээний чанарын баталгааны барьцааг байршуулаагүй талаарх мэдээлэл

№	Төсөл, арга хэмжээний нэр	Шинэ, шилжих	Хэрэгжих хугацаа		2025 онд санхүүжих дүн	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр	Барьцааны хувь	Барьцааны дүн	Тайлбар
			Эхлэх	Дуусах						
1	Аймгийн 18 ЕБС, 22 цэцэрлэгт аяга таваг угаагч, ариутгагч	шилжих	2024	2025	271,040,000	271,040,000	Флекс солюшн ХХК	5 хувь	13,552,000	Байршуулаагүй
2	Хот тохижуулах газрын албан хэрэгцээнд хогийн бункер 10ш	шилжих	2024	2025	80,000,000	80,000,000	Эйч Ди Эс Юу ХХК	5 хувь	4,000,000	Байршуулаагүй
3	Мал эмнэлэгийн газрын албан хэрэгцээнд тоног төхөөрөмж	шинэ	2025	2025	39,600,000	39,600,000	Монтех дистрибьюшн ХХК	5 хувь	1,980,000	Байршуулаагүй
4	Стандарт хэмжил зүйн хэлтсийн албан хэрэгцээнд даралтны аппарат шалгах этолан, лабораторын татах шүүгээ	шинэ	2025	2025	27,000,000	26,800,000	Зэт Ди Эн Смарт Энержи ХХК	5 хувь	1,340,000	Байршуулаагүй
5	Хүнд даацийн автомашины жин хэмжигч зөөврийн авто пүү	шинэ	2025	2025	40,000,000	36,000,000	Нэгм электроникс ХХК	5 хувь	1,800,000	Байршуулаагүй
6	Аймгийн төвийн 35/6 кВ дэд станц 10.3мВт суурилагдсан хүчин чадлыг 16.3мВт болгож нэмэгдүүлэх тоног төхөөрөмж	шинэ	2025	2025	464,116,497	498,113,000	Монхорус интернэшнл ХХК	5 хувь	24,905,650	Байршуулаагүй
7	Аймгийн төвийн цахилгааны нөөц эх үүсвэрийг нэмэгдүүлэх 500кВт хүчин чадал бүхий дизель генератор	шинэ	2025	2025	290,000,000	280,955,074	Анд технологи ХХК	5 хувь	14,047,754	Байршуулаагүй
8	Онцгой байдлын албан хэрэгцээнд эрэн хайх аврах ажиллагаанд ашиглах дрон	шинэ	2025	2025	42,000,000	31,490,000	Хос анар ХХК	5 хувь	1,574,500	Байршуулаагүй

9	Аймгийн төвийн халаалт, цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, засварын ажлын материал	шинэ	2025	2025	400,000,000	368,686,500	Би Би Ди Эм ХХК	5 хувь	18,434,325	Байршуулаагүй
10	Зөөврийн хурд хэмжигч багаж	шинэ	2025	2025	50,000,000	50,000,000	Смарт трафик ХХК	5 хувь	2,500,000	Байршуулаагүй
11	"Сүү" хөтөлбөр	шинэ	2025	2025	300,000,000	183,910,860	Витамилк ХХК	5 хувь	9,195,543	Байршуулаагүй
12	Эрдэнэдалай сумын ЕБС-ийн дээврийн засвар	шинэ	2025	2025	263,935,098	246,149,337	Баян дөхмийн хурд ХХК	5 хувь	12,307,467	Байршуулаагүй
13	Аймгийн төвийн нэгдсэн камержуулалт	шилжих	2024	2025	1,845,230,511	1,845,230,511	Бодь электроникс ХХК	5 хувь	7,126,738	85,134,788 төгрөгийг банкны баталгаа хэлбэрээр байршуулсан. 7,126,738 төгрөг дутуу байршуулсан.
14	Халаалтын зуухнуудын шинэчлэл /"Дундговь-Ус" ОНӨҮГ/	шинэ	2025	2025	809,448,960	809,448,960	Бэсүжин Констракшн ХХК	5 хувь	40,472,448	Барьцааг хугацаанаас нь өмнө чөлөөлсөн.
	Дүн								153,236,425	

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn ᠏ᠨ